

Зураасан зургаар чимэглэсэн нэгэн үйсэн сав

Чунагийн Амартүвшин^{1, *}, Баянбилэгийн Дашзэвэг²

Товч агуулга: Энэхүү өгүүлэл нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ширийн чулууны Зүүн хотгор дэрсний 6-р хүннү булшнаас олдсон нэгэн зурлага дүрс бүхий үйсэн савны талаар юм. Энэ талаар өгүүлэхдээ дэлхийн улс түмнүүдийн болон нүүдэлчдийн хусны үйсний хэрэглээ, уламжлалын талаар өөрсдийн хэмжээнд цуглуулсан эх хэрэглэгдэхүүнийг багцлан авч үзэхийн зэрэгцээ үйсэн савны дээрх зургийн өгүүлэмж, утга агуулгын талаар саналаа тусгана. Мөн тухайн олдвор гарсан булшны оршуулгын зан үйлийн онцлог талууд болон он цагийн асуудлыг товч хөндөх болно.

Түлхүүр үг: Хүннү, үйсэн сав, зураасан зураг

Удиртгал

НТӨ III зуунд Монголын тэгш өндөрлөгт оршин тогтнож байсан хүрэл, төмрийн түрүү үеийн хүчирхэг нүүдэлчин овог аймгуудын нийгэм, аж ахуй, соёлын олон талыг өвлөн Хүннүгийн төрт улс байгуулагдсан билээ. Тэд хэл, соёл, угсаа гарвацийн хувьд харилцан адилгүй овог аймгуудыг эгнээндээ нэгтгэж, нэгдмэл зохион байгуулалтыг бий болгохын зэрэгцээ олон зууны туршид өвлөгдсөн зарим зан үйлийг өөрчлөн шинэчилж байсан нь археологийн дурсгал, эд өлгийн зүйлсээс тодорхой харагддаг. Үүний нэг жишээ бол Хүннү нар Алтай нуруунаас Хянганы нуруу хүртэлх өргөн уудам нутагт оршин тогтнож байсан эртний хүчирхэг овог аймгийнхны үхэгсдээ оршуулдаг зан заншлыг гадаад, дотоод зохион байгуулалтын талаас богино хугацаанд бүхэлд нь өөрчилсөн юм. Үүнд нэг талаас төрийн нэгдмэл зохион байгуулалт, нөгөө талаас нийгмийн өөрчлөлт, олон соёлын нийлэгжилт нөлөөлсөн нь дамжиггүй.

Хүннүгийн булш оршуулгын дурсгалыг дотор нь язгууртны, жирийн буюу жижиг гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваан авч үздэг. Энэхүү хоёр оршуулгын хэлбэр нь гадаад, дотоод зохион байгуулалтаараа эрс ялгаатай боловч зарим зан үйл, түүнд дагалдуулах эд өлгийн зүйлийн төрөл зүйн хувьд адил байдаг. Хүннү нар талийгаачид зориулан бие даасан тахил, хойлгын хэсгийг бий болгож, түүнд элдэв хэлбэр хийцтэй шавар, төмөр, хүрэл, мод, үйсэн сав суулганд идээ, ундаа тавьж эхэлсэн юм.

Бид энэ удаад Дорноговь аймгийн Алтанширээ сумын Ширийн чулууны Зүүн хотгор дэрсний 6-р

хүннү булшны (Ex.10.21) тахилын хэсэг орчмоос олдсон (Амартүвшин нар. 2022; Carolus et al. 2024) нэгэн ховор чамин зурлага дүрс бүхий үйсэн савны талаар тусгайлан авч үзэх болно.

Дэлхийн улс үндэстнүүд мод, модлог ургамал, түүний навч, холтсыг ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг байсны дотор бичиг бичих, зураг зурах дэвсгэр болгодог байв. Тухайлбал, Египетэд паприус (papyrus), Хятадад хулс (bambusa) зэрэг модлог ургамлыг боловсруулан бичгийн цаас гарган авч байсны нэгэн адил монголчууд ч гэсэн өөрсдийн нөөц бололцоог ашиглан хусны үйсээр бичгийн цаасыг орлуулан ашиглаж байв.

Хусны үйс нь боловсруулахад төвөггүй, олдоц элбэг материал болохын зэрэгцээ цаг агаарын өөрчлөлт болон чийгт тэсвэртэй чанар нь түүнийг олон зууны туршид бичгийн хэрэглэл болгон ашиглах болжээ (Цолмон 2002: 26).

Хус нь навч модны төрөлд багтах бөгөөд овог дотроо хамгийн олон зүйлтэй бөгөөд Европ тив бүхэлдээ (Beck et al. 2016) болон Ази тивийн Япон, Хятад (Mao et al. 2010), Солонгос, Монгол, Алс Дорнод, Сибирийн нутгаар (Koropachinskii 2013) өргөн тархжээ. Харин Монгол оронд 12 зүйлийн хус мод ургадаг бөгөөд навчит модны дотроос хамгийн их тархалттай нь Хавтага навчит хус мод (*Betula platyphylla*) ажээ. Хавтага навчит хус мод нь Хэнтий нурууны баруун хэсэг, Хангайн нурууны зүүн өмнөд хэсэг, Ерөө голын сав газраар элбэг тохиолддог байна (Энх-Амгалан нар. 2020: 38).

Дэлхий дээрх хусны үйсийг ашиглаж байсан хамгийн эртний баримт Неандертальчуудтай холбоотой аж. Тэд хус модны үйснээс давирхай гарган өөрсдийн хэрэгцээндээ ашиглаж байсныг судлаачид тогтоосон байдаг (Schmidt et al. 2019).


Мөн хус модтой дэлхийн аль ч хэсэгт хусны холтос нь барилгын үнэ цэнтэй материал байж ирсэн бөгөөд

¹ МУИС, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим, Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

² ШУА-ийн Археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: amartuvshin.ch@num.edu.mn

<https://orcid.org/0000-0001-9077-8438>



Газрын зураг 1. Зүүн хотгор дэрсний хүннүгийн оршуулгын газрын байршил

Умард Азийн улс орнуудад үйсийг сав суулга, цаас, завь, урц майхны бүрээс, нум зэргийг хийдэг байсан бол Хойд Америкийн уугуул оршин суугчид завь хийхийн зэрэгцээ газрын зургаа түүн дээр нь зурж (Hayes 2015: 152), багаж хэрэгсэл, сав суулга, хувцас хунартаа хүртэл ашигладаг байжээ.

Скандинавын хойгийн ард түмнүүд барилгын дээвэрт ашиглахын зэрэгцээ элдэв хайрцаг сав, хувин, загас агнуурын хэрэгсэл, гутал хувцас хийж, мөн л цаасны оронд хэрэглэж байсан (Арциховский и др. 1978) бол Энэтхэгт хусны үйс, хатаасан далдуу модны навчнууд нь цаасны оронд өргөн хэрэглэгдэж байжээ. Дээрхээс гадна Афганистанаас ирсэн Буддын шашны хамгийн эртний гар бичмэлүүд (Гандхарын буддын шашны зарим бичвэрүүд) хусны үйсэн дээр бичигдсэн байсан юм (Jeremaih 1982: 8-9).

Канадын баруун урд хэсгийн шинэ чулуун зэвсгийн үеэс дундад зууны үед холбогдох булш, оршуулга, бууц суурины малтлагаас үйсээр хийж, зураг чимэг зурсан сав суулганы зүйлс олон тоотой олдож байсан бөгөөд тэдгээрийг ихэвчлэн жимс жимсгэнэ, загас хийж, хадгалж байсан бөгөөд мөн судлаачид үйсэн сав суулгыг эмэгтэйчүүдийн хийдэг өвөрмөц үйлдвэрлэл бөгөөд энэ нь зарим талаараа

шүтлэгийн шинж чанарыг ч агуулдаг байсан хэмээн үзжээ (Shannon et al. 2013: 83-122).

Харин монголчууд бидэнд модны холтос үйсийг ахуй амьдралдаа ашиглах дадал, заншил эртнээс өвлөгдөн ирсэн байдаг. Тэдгээрээс цөөн хэдийг дурдвал, Цаатан нар урц сууцны бүрээс, сүү сүүн бүтээгдэхүүн хадгалах сав суулгаа хусны үйс, холтсоор хийх нь элбэг байжээ. Тэд үйсэн борви (дөс суу) буюу бортого сав хийхдээ хусны үйсийг хуулан цагаан хальсыг нь авч дугуйлан эсгэж авдаг. Тэдгээр савны хажуу хана буюу эх бие болох үйсээ ёроол хийх дүгрэг үйсэн дээр тавьж уулзварыг гадагш нь дэрвийлгэн ноосон утсаар гурван давхар оёно. Хажуу ханан талын нийлсэн хоёр амыг мөн үйсээр даруулан 2-3 давхарлан оёно. Амсрын дээд тал, бүсэлхийд үйс даруулан 2-3 давхар ширнэ. Борвины таглааг хуурай хушаар зорж, гар тохируулан гурвалжин хэлбэртэй үйсээр таглаа хийдэг. Борвийг жил тутам шинээр хийдэг боловч 10 шахам жил засаж сэлбэн хэрэглэж болдог ажээ. Үйсэн борвинд сүү, ээдэм хийж хадгалдаг. Борви, хэмжээний хувьд харилцан адилгүй байна (Бадамхатан 1962: 28, 30).

Буриадууд ч гэсэн хусны шүүс хамгийн их байх үеэр урлах савны хэмжээгээр хусны бүдүүн нарийныг

сонгон авч тайран, түүний хальсыг битүү хуулан авдаг аргатай байжээ. Хусны хальсаа хатаан, савны дотор гадраа үйсээр урлан, улиасаар ёроол, таг хийж өрөм, зөөхий шар тос хадгалах нэн тохиромжтой үйсэн бортого хувин хийдэг байна (Батнасан 2012: 24). Мөн буриадын бөө нарын чандрыг үйсэн саванд хийж оршуулдаг байжээ (Гантогтох 2012: 54).

Мөн Монгол Хамниган нар хус үйсний хэрэглээ боловсруулалт онцгой байр суурь эзэлж, тэдний угсаатны шинжийг ахуй соёлын талд илэрхийлэхүйц өргөн хүрээг хамардаг ажээ. Байгал, Амар мөрний чигт суурьшиж байгаад XX зууны эхээр Монголд ирж суурьшсан Хамниганчууд үйсээр ахуйн сав суулга болох матал, байлгана, тэвш, аяга, ан амьтан дуудах шившүүр зэргийг хийдэг байжээ.

Тэдний аарц хийдэг байсан нэгэн уламжлалт арга нь намар аажуу аарцаа хусны үйсээр том хэмжээний ёроолгүй сав (хусны үйсэн торх)-нд хийж хонины ноосон утсаар оёод түүнийгээ газарт тавин дээрээс нь өдөр өдрийн аарцаа хийсээр бараг дүүргэн дээгүүр нь юмаар бүтээж хүлэн зуссан нутагтаа орхино. Аарцны нь шар ус зун, намаржингаа газар луу шингэж хөлдөнө. Өвөлжөөндөө буусны дараа чаргатай ирээд мөнөөх үйсэн савтай аарцаа газраас нэгэн төө хэртгэйгээр тайрч өвөл хавартаа ихээр нөөцөлсөн аарцаа буцалгаж ууцгаадаг.

Хамниган нар жил бүрийн 6-р сарын дундаас хойших долоо хоногт дол гүйх үеэр хусны хальс хуулахдаа нэг тайрсан модноос 7 битүү (сав) гарахаар бодож хэрэгцээ хангасан ганц нэг мод тайрч “Үйсэн сав” (түйс) хийдэг байжээ. Ингэж үйсэн сав хийхдээ уул мод ургаж байхдаа ёзоор байсныг нь савныхаа амсар болохоор тааруулна. Яагаад гэвэл мод үзүүр тал руугаа огшиж хатдаг ажээ (Баттуяа 2006: 32, 242).

Тува цаатан нар урцаа үйсээр бүрдэг байсан бөгөөд тэд залуу хусны үйсийг 3 хоног усны ууранд болгон дараа нь хуулан бүрхээр (архины) мэт хэлбээд тогоотой буцалсан усанд холтсоор бүтээн (түлэгдэхээс болгоомжилж) тавьж буцалгахад өнгө нь хүрэнгэн зөөлрөхөд уснаас авч, хонины ноосон утсаар (дээр үед цааны шөрмөсөөр) дээд, доод бүрээсэнд тааруулан залгаж оёдог. Үйс, холтсон бүрээс нь өвөл дулаан, зун борооны дусаал гоождоггүй, зөвхөн нүүдэлд тохиромжгүй гэдэг. Мөн тэд үйсэн борви (Дос суу) хэмээх нэгэн савыг өргөн хэрэглэдэг байжээ.

Хусны үйс хуулахдаа цагаан хальсыг нь авч дугуйлан их бие хийх үйсээ эргэж авна. Тэгээд борвины их хажуу ханыг (трапец маягтай) бие болох үйсээ ёроол хийх дүгрэг үйсэн дээр тавьж уулзварыг нь гадагш дэрвийлгэн (шүдээрээ хазна) ноосон утсаар гурван давхар оёно. Хажуу ханан талын нийлсэн хоёр амыг мөн үйсээр хавчин 2-3 давхарлан хонины ноос томж оёно. (Цааны шөрмөсөөр оёход сүү нэвтэрдэг). Амсрын дээд тал, бүсэлхийд үйс даруулан давхар

ширнэ. Борвины таглааг хуурай хуш зорж аманд нь тааруулан хийдэг. Жил бүр шинэ борви хийдэг боловч, нэг борвийг засаж сэлбээд байвал 10 шахам жил ашиглаж болдог ажээ. Хэмжээний хувьд борвинууд янз бүр, хамгийн жижиг борвины (хүүхдийн) суурийн голч 13 см, амны голч 9 см, өндөр 9 см, дунд зэргийн борвины (саалийн) суурийн голч 19 см, амны голч 11,5 см, өндөр 13 см, том борвины (сүү нөөцөлдөг) суурийн голч 39,5 см, амны голч 23,5 см, өндөр 21 см байна (Бадамхатан 2012:183).

Мөн халхууд үйсээр хутганы ишний гадаргууг бүрдэг, дарханы хэв цутгуурт хэрэглэдэг лавыгаа хусны үйсэнд суулгадаг (Дисан 2012: 142) бол харин торгууд нар эмээлээ урлан чимэглэхдээ хусны үйс ашигладаг (Тангад 2012: 144).

Түүнээс гадна Амар мөрний захаар нутаглах Гилякуудын хэрэглэж байсан үйсэн аяга буюу “тотангры” нь Монгол Хамниганы чумантай төстэй бөгөөд ур хийц сайтай доорх ёроолд нь гоёмсог хээ цоолборлож, амсрыг нь дэлбийлгэн хийдэг байжээ (Шренк 1883). Мөн Түнгүсүүд үйсэн сав суулгаа элдэв янзаар хөвөрдөн оёж, чамин хээ цоолборлож чимдэг байна (Диосеги 1950). Монголчуудын дунд ч гэсэн үйсэн сав суулгаа хээгээр чимж, өнгө ялгасан зураг зурах уламжлал хадгалагдан үлдсэн байдаг (Баттуяа 2006: 36).

Мөн буриадууд хус модыг шүтэн биширч, өөрсдийн уламжлалт зан үйлдээ нягт шингээхийн зэрэгцээ түүнийг ахуй амьдралдаа өргөнөөр ашиглаж байжээ. Тэд хусаар гэрийн тооно, багана, тэрэгний эд анги, арьс элдэх гар, хөл, өвдөг талхи, морины уяа зэргийг хийх бөгөөд хурим болон бөөгийн зан үйлийн салшгүй нэгэн хэсэг болж байв.

Хүннү нар хусны үйсийг сав суулга (Төрбат нар 2003: 239-240, 242), түүний таг (Амартүвшин нар 2010: 187), элдэв чимэглэлд (Төрбат нар 2003: 241) ашиглаж байсан нь археологийн эх хэрэглэгдэхүүн дотор олонтоо тохиолддог. Өмнөх үед буюу хүрэл, төмрийн түрүү үеийн археологийн дурсгалууд дотор үйсээр хийсэн эд зүйлс тэр бүр тохиолдоод байдаггүй нь тэднийг хэрэглэдэггүй байсан гэсэн зүйл огт биш бөгөөд магадгүй энэ нь оршуулгын гүн, хадгалалтын байдал, оршуулгын зан үйл гэсэн гурван зүйлийн аль нэгнээс нь хамааралтай аж.

Харин хүннү нар оршуулгыг харьцангуй гүнд хийдэг болсны зэрэгцээ талийгаачид зориулсан хойлго, тахилын хэсэгт идээ, ундаа, зоог, шүүс дагалдуулдаг болсноор шавар, хүрэл, төмөр, үйс, модон сав суулгууд хамт хэрэглэгдэх болсон байна. Үйсэн сав суулга нь цагаан идээ болон жимс жимсгэнэ урт хугацаатай хадгалахад тохиромжтой болох нь дээр дурдсан өнөөгийн зарим нүүдэлчдийн сав суулганы цуглуулгаас тодорхой харж болох бөгөөд тухайн үед ч гэсэн ийм шалгуураар өргөн ашиглагдаж байсан нь дамжиггүй.



Зураг 1. Зүүн хотгор дэрсний 6-р булшны дараас, оршуулгын зураг

Эх хэрэглэгдэхүүн

Энэхүү үйсэн сав олдсон булш нь Зүүн хотгор дэрсний 5-р булшны баруун урд талд залгаа буюу газарзүйн байршил нь хойд өргөргийн $45^{\circ} 46' 57.2''$, зүүн уртрагийн $110^{\circ} 38' 52.3''$ солбицол, далайн түвшнээс дээш 1123 м өндөрт өргөгджээ.

Булшны дараасыг цэвэрлэх явцад чулуун зэвсгийн зүйл, ваарын хагархай зэрэг олдворууд олдож байсан бөгөөд малтлага 65-68,5 см гүнд хүрэхэд дараасны төв хэсэгт жижиг дугуй хэмжээтэй чигжээс чулуу илэрсэн юм.

Цааш малтлагын гүн 127-133 см болоход үргэлжлэн цөөн тоотой чигжээс чулуу гарахын зэрэгцээ хойд талаар байгалийн хатуу хөрс ялгарч байв. Энэ үеэс ваарын хагархай болон хүний шүд зэрэг зүйлс олдож байлаа.


Малтлагын гүн 153-169 см болоход чигжээс чулуу 220×103 см хэмжээтэй талбайг эзлэн шигүү байсан. Чигжээс чулууны завсар зайгаас шатсан ясны хэсэг, ваарын хагархай, бог малын шүдний хугархай зэрэг зүйлс гарч байв. Харин оршуулгын нүхний хөл талаас өвөрмөц хийц бүхий модон зүйл илэрсэн юм. Энэ нь хөндлөн дөрвөн мод байх бөгөөд баруун талын захаар 3 см өргөнтэй хавтгай модоор эмжсэн. Урт нь 17 см. Тэдгээр нь төгсгөл хэсэгтээ дарагдаж цөмөрсөн. Зүүн талын ирмэгээр нарийн савхан мод тавьжээ. Савхан модны голч 0,8-0,9 см. Урт нь 17,5 см. Хөндлөн модны өргөн 4 см, 5 см, 6,5 см, 7,5 см гэсэн янз бүрийн

хэмжээтэй. Хөндлөн модны дээгүүр 5-6 см зайтай савхан моднуудыг сараалжлуулан тавьсан байна. Дөрвөн модны зузаан 2,5 см, 3,5 см. Энэхүү зохион байгуулалтын хадгалагдаж үлдсэн хэмжээ $59 \times 33,5$ см талбайд байна.

Дээрх савхан мод бүхий бүтэцтэй залган хөндлөн банз 14 ш байх бөгөөд түүний өргөн 5-6 см, зузаан 4 см. Хөндлөн банзны урт 102,5 см, баруун тал урт банз 102 см, зүүн талын банз 59 см байна. Дунд байсан дөрвөлжин хэсэг 57,5 см өргөн, 19 см урт хэмжээтэй. Үүн дээр нийт 15 ш нүх гаргажээ. Нүхний хэмжээ 6×6 см. Хүрээний өргөн 3,5 см.

Ингээд малтлага 175-183 см гүн болоход оршуулгын нүхний хөл болон цээжин хэсэгт чигжээс чулуу хэд хэд байсан бөгөөд тэдгээрийн доороос авсны модон таг гарч эхэлсэн юм. Баруун талын авсны модон тагны урт 180 см, өргөн толгой талдаа 23 см, голдоо 22 см, хөл хэсэгтээ 20 см. Голын тагны урт 90 см, өргөн 30 см, зүүн талын таг модны урт 155 см, өргөн 29 см, хөл талдаа 14 см байв.

Гүн 191-199 см болоход хойд хананаас 50 см зайтай богийн дал, хавирга, ваарын хагархай, хүний эрүү, төмөр эдлэлийн хэсэг зэрэг зүйлсийг бөөгнүүлэн хаясан байв. Энэхүү бөөгнөрсөн хүн, малын яс, ваарын хагархайны доороос хойш хандуулсан дугуй толгойтой шөвөг мэт төмөр эдлэл гарав. Толгой талын хашлаганаас 38 см, баруун хананаас 18 см зайтай ваарын бөөрний хэсэг, түүний урд талд буюу хойд хананаас 55 см, баруун хананаас 15 см зайтай хүний



Зураг 2. Үйсэн сав анх илэрч олдсон болон сэргээн засварласны дараах байдал


шууны яс, түүний урд талд дугуй хэлбэртэй ардаа товгортой төмөр эдлэл гарав. Толгой талаас 83 см, баруун хананаас 16 см зайтай хоёр том төмөр эдлэл гарсан. Баруун талынх нь 8×12 см, зүүн талынх нь 11,5×9 см, зузаан 2,3 см. Мөн хоёр дунд чөмгийн толгойн завсар босоо байдалтай нэгэн хавтгай төмөр байна. Дунд чөмгийн дотор талд хүрэн өнгийн нэгэн сувс байв. Мөн шигшүүрээс шилэн сувс хэд хэдэн тоотой гарсан юм. Урд талд буюу зүүн дунд чөмгийн голд үзүүр нь зүүн хойшоо хандсан ойролцоогоор 16 см урт модон бариултай төмөр хутга байсан. Хоёр дунд чөмгийн толгой завсар хавтгай төмөр босоо маягтай байв. Баруун сүүжний толгойн гадна талд өөр нэг хавтгай төмөр байна. Баруун урд тал буюу хана хэсгээс хүний гараар засаж хийсэн чулуун багаж (эдлэл?) гарсан.

Оршуулгын толгой талаас буюу баруун хананд шахсан маягтай ваарын суурь хэсгийн хагархай хэсэг олдов. Түүний урд талаас буюу 203 см гүнээс дотроо хагархай хүрэл толь бүхий гадуураа сараачмал зураг бүхий дугуй үйсэн сав гарсан.

Үйсэн савыг гурван хэсэг үйсийг хөндлөнгөөр нь нугалж, нугалаас хэсгийн амсарт тааруулан хийжээ. Залгаасыг нааж хийсэн бололтой ул мөр мэдэгдэхийг зэрэгцээ нэг залгаасны амсар хэсэгт 0,6 см урт ташуу

оёдлын мөр, утасны хэсэг хадгалагдсан байна. Харин нийт үйсийг тойруулан хоёр үзүүрийг нийлүүлэхдээ гадна талаар нь орж ирсэн хэсгийн үзүүрийг нарийн урт догол гарган дотор тал руу нугалан ташуу маягтай оёжээ. Савны амсар хэсгийг ялимгүй дэрвэгэр, бөөр хэсгээрээ хотгор, ёроолыг эх биеэс ялимгүй илүү гарган ур гарган хийсэн байна. Савны голч амсар хэсгээрээ 10,2 см, ёроол хэсгээрээ 10,7 см. Савны өндөр 5,4 см, зузаан 0,4 см (Нандинцэцэг 2023: 109). Савны гадна талаар тойруулан нарийн үзүүртэй зүйлээр сараачмал зураг зурсан. Эдгээр зургийг гол залгаасыг баримжаа болгон баруун гар тал руу тодорхойлов.

1-р дүрслэл. Залгаасны үзүүр хэсэгт 2,5 см өндөр цомцог буюу хүзүүвчин тоонот (Монгол гэр 2015: 11-12) гэрийн дүрслэл бий. Хүзүүвчин тооныг нарийн эмжээртэй маягтай дүрсэлсэн. Гэрийн дээвэр, хана, туургыг бүхэлд нь ханан хээгээр эрээлж, хаалгыг хоёр хавтастай маягтай зуржээ. Дээврийн урдуур даруулга маягтай зүйлийг дүрсэлсэн нь тодорхой харагдана. Мөн гэрийн хаяавч хэсгийг хөндлөн зураасаар зааглан ханан хээгээр чимэглэхдээ зүүн талын хаяанд догол маягийн дөрвөлжин зурсан нь магадгүй энэ нь гэр тэрэгний тавцан дээрх хашлагыг дүрсэлсэн байж болно. Хаяавч эсвэл тавцангийн доогуур хөндлөн өргөн зураас зурж, түүний доогуур босоо, хөндлөн,



Зураг 3. Үйсэн савны дээрх зураасан зургууд

чагт маягийн элдэв зураас сараачжээ.

2-р дүрслэл. Гэрийн баруун талд, гэртэй хэд хэдэн зураасаар холбосон нэгэн тэгш өнцөгт дөрвөлжин дүрс байна. Энэ дүрсний хэмжээ 2,5×2,7 см. Дээд тал буюу орой хэсэг нь ялимгүй бөмбөгөр, доошоо шувтан хүнхэр хэлбэртэй. Зүүн тал буюу гэр талдаа нэг догол гарган дөрвөлжлөн 0,1-0,2 см өргөнтэй эмжээр зурсан байна. Дөрвөлжилсөн эх биеийн голоор баруун тал руугаа өлийсөн 0,2-0,4 см өргөнтэй ташуу дүрс гаргаад дээр талын үзүүрийг эх биеэс ялимгүй гадагш илүү гаргажээ. Энэ ташуу дүрсээр зааглагдсан эх биеийг хоёр өөр хээгээр чимэглэсэн. Дээд талын хэсгийг босоо зураасан хээ гаргасан бол доод талын хэсгийг цэг маягийн дугуй дүрс гаргаад баруун талаар нь хөрөөний ир мэт хээг босоогоор нь зуржээ. Энэ дөрвөлжин дүрслэлийн доор “уул”, “долгио” маягийн хээтэй төстэй мөлгөр үзүүртэй гурвалжингуудыг нэг нэгийг нь дамнуулан гурван эгнээ гаргасан байна. Түүний доогуур хөндлөн урт хоёр зураас гэр хүртэл үргэлжлэх бөгөөд түүний доор 0,3-0,4 см голчтой дөрвөн дугуйг цувруулан дүрсэлжээ. Дөрвөн дугуйны тэг дундуур нэг хөндлөн зураас татсан байна.

3-р дүрслэл. Энэхүү гэр болон дугуйтай дөрвөлжин зүйлийн баруун талд тэгш оройтой, хоёр тал руугаа хотойсон хүнхэр маягийн босоо дүрслэл байна. Зүүн талын дүрслэлийн оройг 0,1 см өргөнтэй эмжээр маягтай зураас зурж, хэд хэдэн босоо зураасыг суурь хүртэл сараачсан байна. Уг дүрслэлийн өндөр 1,9 см, орой хэсгийн өргөн 2,1 см, суурь хэсгийн өргөн 1,4 см.

4-р дүрслэл. Түүний баруун талд залгаа маягтай төстэй хэлбэртэй нэгэн дүрслэл бий. Мөн хавтгайдуу оройтой, хоёр талаараа хотойсон хүнхэр ханатай, бүх талыг ойролцоогоор 0,1 см өргөнтэй эмжээр гаргасан зурсан. Дүрслэлийн голоор нь 5 босоо зураас татан


голын зурааснаас доош хоёр тал руу ташуу зураас татаж гурвалжилсан хээ (“мод” маягийн) гаргажээ. Энэ дүрслэлийн өндөр 2,8 см, орой хэсгийн өргөн 2,3 см, суурь хэсгийн өргөн 1,8 см. Дүрслэлийн орой хэсгийн баруун гар талд гурвалжин дүрсийг доош хандуулан дүрсэлсэн байна.

5-р дүрслэл. Дээрх хоёр ойролцоо хэлбэртэй дүрслэлийн ард “өндгөн” хэлбэрийн нэгэн дүрслэл бий. Уг дүрслэлийн өндөр 2 см, суурь хэсгийн өргөн 1,2 см. Дүрслэлийн талбайг хоёр хэсэгт хуваан орой хэсэгт шигүү ханан хээг гаргасан бол суурь хэсэгт нь арай таруу маягтай ханан хээ тавьсан байна. Дүрслэлийн орой хэсэгт 0,1 см өргөнтэй эмжээр гаргажээ. Энэхүү “өндгөн” хэлбэрийн дүрслэлийн суурь нь тэгш бөгөөд түүнийг ойролцоогоор 0,3 см голчтой цувраа хоёр дугуй бүхий 0,2 см өргөнтэй тавцан маягийн зүйл дээр тавьсан байна. Дээр дурдсан орой болон суурь гэсэн хоёр хэсэгт хуваасны зүүн талаас хөндлөн болон босоо зураасаар суурь хэсгийг нэвт гарган хамгийн доод талын хөндлөн зураасанд хүртэл татжээ.

6-р дүрслэл. Энэ дүрслэлийн баруун талд бөмбөгөр орой хэсэг л мэдэгдэх төдий сараачмал дүрс байна. Энэ хэсгийн хэмжээ ойролцоогоор 3,5×3,5 см. Хөндлөн ташуу болон чагт хэлбэрийн зурааснууд тод мэдэгдэх бөгөөд өмнө тодорхойлогдсон бөмбөгөр болон тэгш оройтой хүнхэр маягийн дүрслэлтэй ижил зүйл зурах гэсэн бололтой.

7-р дүрслэл. Элдэв сараачмал дүрсний баруун талд тэгш дэрвэгэр оройтой дөрвөлжин дүрс болон бөмбөгөрдүү оройтой өндөр дүрсийг цувруулан чарга (завь?) маягтай зүйл дээр суурилуулснаар дүрсэлжээ. Энэ дүрслэл үйсний залгаанд таарч зарим зураас тодорхой сайн мэдэгдэхгүй. Дээврийн өргөн 3,1 см, эх биеийн буюу чингэлгийн өргөн 1,5 см, өндөр 1,5 см. Чингэлгийн голд 1,6х1 см хэмжээтэй цонх маягтай зүйл дүрслээд хоёр зураасаар чагталсан байна. Цонх маягийн зүйлийн зүүн доод талд 0,2×0,2 см хэмжээтэй дөрвөлжин дүрс, түүний доор шат маягийн догол бүхий дүрс тус тус зуржээ. Мөн цонх маягийн дүрсний доогуур чагт буюу хана хээ гаргасан нь үл ялиг мэдэгдэж байна. Чарга (завь?) -ны хошуу хэсэг матигар, орой нь тэгш байх бөгөөд ард талд нь мөн нэг 0,2 см өргөнтэй ташуу дүрслэлийг зурж өгчээ.

8-р дүрслэл. Энэ дүрслэлийн баруун талд буюу ард талд нь бөмбөгөр оройтой, дээрээ хоёр зэрэгцээ туг хиур маягийн зүйл хатгасан босоо дөрвөлжин нэгэн дүрслэл байна. Хоёр туг хиур маягийн зүйлийн зүүн талынх нь өндөр (1,5 см), хоёр манжлага (унжлага)-тай, арынх нь буюу баруун талынх нь намхан (0,8 см) нэг манжлагатай ажээ. Орой хэсгийн өргөн 1,9 см, чингэлэг хэсгийн хэмжээ 1,2×1 см. Чингэлэг хэсгийг ханан хээгээр чимэглэсэн байна. Чингэлгийн зүүн баруун талд нь шат маягийн догол бүхий дөрвөлжин дүрс гаргажээ. Суурь хэсгийн дагуур урт ташуу,



Зураг 4. Үйсэн ёроол дахь зураасан зураг

Хүснэгт 1. Зураасан зурагт үйсэн савны дүрслэлийн харьцуулсан хүснэгт

Булшны нэр, дугаар	Дүрслэл					
	Тэрэг	Туг / сүлд	Дугуй	Чарга	Гэр	Хүн, амьтан
Бурхан толгойн 79-р булш	+	-	+	-	-	-
Царамын 7-р булш	+	+	+	-	+	-
Зүүн хотгор дэрсний 6-р булш	+	+	+	+	+	-

хөндлөн босоо янз бүрийн зурааснууд зурсан байна.

9-р дүрслэл. Түүний араас буюу 1-р дүрслэлийн урд залгаа маягтай өөр нэгэн матигар хошуутай чарга (завь?) дээр өмнөхтэй ижил хэлбэртэй дүрслэл зуржээ. Чарганы хошууг өмнөх шиг төгс гаргалгүй сараачмал зураасаар арзайлган гаргасан байна. Бөмбөгөрдүү оройтой доошоо шувтан маягийн дээвэр болон ханан хээ бүхий дөрвөлжин чингэлгийг дүрсэлсэн байна. Орой дээр мөн урд талдаа хоёр манжлагатай, хойд талдаа ганц манжлагатай туг хиур дүрсэлсэн байна. Урд талын тугийн өндөр 1 см, хойд талынх 0,5 см. Бөмбөгөр орой хэсгийн өргөн 2 см, чингэлгийн хэмжээ 1,2×0,9 см. Чингэлгийн баруун зүүн доод талд шат маягийн доголтой дөрвөлжин зурсан. Баруун талын шатны доод гишгүүр дээр босоо 1 см урт туг маягийн зүйл нэгийг сийлжээ. Чарганы суурь хэсэгт буюу чингэлгийн харалдаа 0,3×0,2 см хэмжээтэй дөрвөлжнийг дүрслээд түүнээс ялимгүй зүүн урд талд 0,3×0,2 см хэмжээтэй өөр нэг тэгш өнцөгт дөрвөлжин дүрсэлсэн байна.

10-р дүрслэл. Үйсэн савны ёроолд мөн сараачмал дүрснүүд бий. Баруун талд нь дээрээ 0,5×0,2 см хэмжээтэй дөрвөлжин дүрстэй 2,3×2 см хэмжээтэй нэг дөрвөлжин байна. Доод талын том дөрвөлжин ханан хээгээр хээлсэн.

11-р дүрслэл. Түүний баруун дээд талд мөлгөрдүү ирмэгтэй догол бүхий дөрвөлжин дүрс байна. Түүний голоор чагт маягийн дүрс гаргаад зүүн талын гурвалжин хэсгийг босоо зураасаар дүүргэсэн байна.

12-р дүрслэл. Энэ хоёр дүрсний доогуур ханан хээ маягийн дүрс болон хөндлөн, ташуу, босоо янз бүрийн

зурааснуудыг 7×4,5 см хэмжээтэй талбайд зуржээ.

Өмнө нь хүннүгийн булш оршуулгын дурсгалаас гарсан үйсэн савны дээр тэрэг дүрсэлсэн гурван тохиолдол бүртгэгдсэн байдаг. Үүнд, Монгол Улсын Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бурхан толгойн 79-р булш (Төрбат нар. 2003), ОХУ-ын Буриадын Царамын язгууртны 7-р булшнаас (Minyaev 2009: 55) багтаж байна.

Бурхан толгойн 79-р булшны үйсэн таг нь дээрх дөрвөн тэрэг нь 12 ба 8 хигээст дугуйтай, дөрвөлжин хэлбэрийн мухлаг, орой нь дугариг хэлбэрийн халхтай бөгөөд түүний дээр цацаг дүрсэлсэн (Хавсралт). Мухлагийн цонхонд хос зураасаар ташуу хаалт хийсэн. Нэг тэрэгний урд шовх гурвалжин хэлбэртэй урц бололтой зүйл дүрсэлсэн байжээ (Төрбат 2015: 49-53). Царамын 7-р булшнаас ёроол болон эх бие гэсэн хоёр хэсэг болсон үйсэн сав олдсон байна. Эх биеийн гадуур том, жижиг 6 ширхэг бөмбөгөр хэлбэртэй гэр, мухлаг болон туг сүлд дүрсэлсэн байжээ (Хавсралт 2).

Дүрслэлийн онцлог

Үйсэн савны дээр дүрслэгдсэн гэр болон бүхээгийг дотор нь цомцог гэр хэлбэрийн, хүнхэр хэлбэрийн бүхээгтэй, зууван дугуй хэлбэрийн бүхээгтэй, дөрвөлжин бүхээгтэй хэмээн дөрөв ангилж болохоор байна. Эдгээр дээр дүрсэлсэн хээг дотор нь ханан, загасан нуруу, туузан, цэгэн гэсэн мөн дөрвөн хэсэгт хувааж болно.

Үйсэн савны дээр дүрслэгдсэн бүхээгүүдийн орой нь ялимгүй ялгамжтай байгаа юм. Энэ нь

Хүснэгт 2. Зураасан зурагт үйсэн савны дүрслэлийн харьцуулсан хүснэгт

Бүхээгийн хэлбэр Хээний төрөл	Цомцог гэр	Хүнхэр хэлбэр	Зууван дугуй	Дөрвөлжин
Ханан хээ	1		5	2; 7; 8; 9; 10, 11
Загасан нуруу хээ		4		
Туузан хээ		3		2
Цэгэн хээ				2

сийлбэрчийн ур чадвартай холбоотой юу эсвэл зориуд ялгаатай талыг гаргах гэж хичээсэн үү гэдэг нь тодорхойгүй. Гэхдээ л бөмбөгөр, ялимгүй бөмбөгөр, тэгш гэж гурван өөр дүрслэл ялгарч харагдана. Үүнээс 7-р бүхээгийн дүрслэл нь дээврийн үзүүрийг дээш сэргийлгэн, хавтгай оройтой байгаа нь сүм дуганыг санагдуулам аж. Гэхдээ оройд нь ямар нэгэн ганжир, орой дүрслээгүй байна. Ийм маягийн хэлбэр хийцтэй тэрэгний дүрслэл Хятадын археологийн баримтад цөөнгүй байдаг билээ (Crouwel and Linduff 2024: 21).

Өөр нэгэн сонирхолтой хэлбэр бол хоёр дугуйтай арал, шалан дээр ханан хээгээр чимэглэсэн нэгэн хавтгай суурьтай зууван дугуй (өндгөн) хэлбэрийн нэгэн бүхээг (5 дугаартай) бий. Энэ нь хүн тээвэрлэх гэхээсээ илүүтэй онго шүтээн, сүлд залсан бүхээг бололтой харагдана. Ийм маягийн эсгийн бүрээстэй мухлагт сүлд залж байсан баримт Үзэмчин нарын дунд байсан талаар мэдээ бий (Дисан 2012: 129).

Дүрслэлийн 8, 9-р бүхээг тун адилхан дүрсэлсэн байна. Ялимгүй бөмбөгөр, хоёр тал руугаа илүү гарсан орой, ханан хээгээр чимэглэсэн дөрвөлжин мухлаг, хоёр талд байх гишүүр маягийн зүйл зэрэг нь тун адил. Хамгийн сонирхолтой нь бүхээгийн оройн урд талд арай урт хоёр дугуй дүрс цувруулсан дүрс, түүний хойно үзүүртээ ганц дугуй дүрстэй өмнөхөөс арай намхан дүрс юм. Энэ нь Өвөр Байгалын Царамын хүннү булшнаас гарсан үйсэн дээрх зураг (Miniaev and Sakharovskaia 2007: 51), дундад зууны үед холбогдох Монгол Улсын Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайт (Идэрхангай нар. 2017: 327), Байгал нуурын баруун бие Лена мөрний Шишкиногийн (Окладников 1959: 171) хадны зургийн дахь дүрслэлүүдтэй тун төстэй байхаас гадна сүүлийн үеийн Үзэмчин нарын арал шивээг будаж гоёсон тэргэнд залсан сүлд шүтэх заншлын (Дисан 2012: 129) улбаа мэт санагдаж байна.

Үйсэн савны дүрслэл дотор цамхраа буюу цомцог гэрийг чадварлаг сийлсэн нь онцгой содон харагдана. Энэхүү дүрслэл нь Хүннү нарыг гэр сууцанд амьдарч байсан бөгөөд түүнийгээ тэргэнд ачин хөдөлгөдөг байсныг батлах баримтыг нэгээр нэмж байгаа хэрэг юм. Энэ талаар судлаачид тусгайлсан судалгаа олонтоо хийсэн тул (Түвшинжаргал, Тэйлор 2019), (Баатархүү, Одсүрэн 2015) үүнийг дэлгэрүүлэхгүйгээр орхиё.

Цомцог гэрийн дүрслэлийн ард талын буюу 2-р бүхээгийн хэлбэр нь дөрвөлжин хэлбэрийн дээр догол гарган жижиг дөрвөлжин залгаад оройг нь бусад бүхээгүүдтэй адил хоёр үзүүр нь шовх бөмбөгөрдүү дүрсэлсэн байна. Мөн ийм маягийн дүрсийг 11-р дүрслэл буюу үйсэн савны ёроолд мөн зуржээ. Энэ хэлбэр нь бусдаас харьцангуй өөр байгаа нь зураачийн тэрэгний бүхээгийн олон төрөл болон зориулалттай болохыг тодотгож өгөх гэсэн санаа бололтой.

Үйсэн савны нийт дүрслэл дотор бас нэг анхаарал татахуйц зүйл бол 7, 9-р бүхээгийн урд талд буй ээтгэр

дүрслэл юм. Үүнийг харвал яах аргагүй чарга, завь мэт сэтгэгдэл төрүүлнэ. Саяхныг хүртэл ой шугуй, цас ихтэй нутагт ачаа ачих бас нэгэн хэрэгсэл нь хусан чарга байсаар иржээ (Бүнчин 1978: 78). Хусан чаргын гуя нарийн уртавтар, хөндлөвчийг (далавч) ойрхон хийж үхэр эсвэл моринд хөллөн ачаа ачдаг. Чарганы урд талын эрүүний (ээтгэр үзүүр хэсэг Ч.А) хоорондох зайг үхрийн ширээр битүү ширэлдэг байсан байна (Тангад 2012: 247).

Гэхдээ бас нэг зүйлийг заавал анхаарах хэрэгтэй болно. Энэ бол Монгол орны цасан бүрхүүлийн хэмжээ ба үргэлжлэх хугацаа юм. Манай улсын Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсыг багтаасан хойд тал тэргүүлдэг. Энд цасан бүрхүүлийн дундаж зузаан 6-7 см, хамгийн их нь 35-40 см хүрдэг бөгөөд үргэлжлэх хугацаа нь 150-160 хоног аж. Харин өмнө талын говь нутагт цасан бүрхүүлийн дундаж зузаан 2-3 см, хамгийн их нь 14 см байдаг бөгөөд зарим нутгаар цас бүр ч бага ордог, орсон ч удалгүй хайлж уурших тул цасан бүрхүүл бараг тогтдоггүй юм байна. Цасан бүрхүүл арай орой тогтож эрт арилах тул үргэлжлэх хугацаа 120-130 хоног байна (Бадарч, Жамбалжамц 1969: 108-109).

Тэгэхээр өнөөгийн уур амьсгалын нөхцөл байдал хүннүгийн үед нэг их өөрчлөгдөөгүй хэмээн үзвэл тэд гэр сууц, бүхээг ачсан чаргаар улирлын чанартай, богино зайнд хөдөлгөөн-нүүдэл хийж байсан хэмээн үзэж болно. Бас энэ дүрслэлтэй холбоотой үгүйсгэх аргагүй нэг таамаглал бол завь байж болох хувилбар юм. Бид хүннүгийн хил хязгаар, гадаад харилцааг өргөн цар хүрээтэй авч үзвэл завь хөлөглөсөн нүүдэл, тээврийг төсөөлөхөд хялбар бөгөөд түүнийг харж эсвэл сонсож бахадсан урлаачийн буулгасан бүтээл байж болно. Ганцхан жишээ дурдахад Хань улсын үед Хатан гол, Хөх мөрөн болон түүний цутгал голуудыг оролцуулсан усан тээвэр эрчимтэй хөгжиж, түүгээр их хэмжээний үр тариа, бараа таваар тээвэрлэгдэж байжээ (Nanny Kim 2016: 4-6). Тэрхүү усан тээврийн хөлөг онгоцнууд дүрсэлсэн зарим эх хэрэглэгдэхүүнээс харахад хэлбэр төрхийн хувьд бидний үйсэн савны дээрх дүрслэлтэй адилавартай байгааг дурдья (Зураг 5).

Манай үйсэн савны чуулбар дүрслэлийн дотор бас “өндгөн” маягийн хэлбэртэй 5-р дүрслэлд хоёр дугуй, доголтой дөрвөлжин буюу 2-р бүхээгийн доор дөрвөн дугуй дүрсэлсэн байдаг. Хүннүчүүд хоёр (Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2007), дөрвөн дугуйтай (Эрэгзэн 2024: 123) тэрэг хөлөглөж байсныг археологийн хэрэглэгдэхүүнээс тодорхой харж болно.

Зүүн хотгор дэрсний хүннү булшнаас гарсан үйсэн савны дээрх дүрслэлийг бүхэлд нь авч гэр, бүхээг, мухлаг ачсан чарга (завь), тэрэг ажээ. Гэхдээ сийлбэрч эдгээр тэрэг, чаргыг чирэх хүч (морь, үхэр, тэмээ), хөтлөх хүнийг огт дүрслээгүй нь магадгүй нүүдэл суудалгүй тайван байдлыг гаргахыг хичээсэн

байх. Мөн дүрслэл дотор олон төрөлт сууц, бүхээг, тэрэг байгаа нь хөрөнгө чинээ, язгуур угсааг харуулах эсвэл бэлгэдсэн байж болох юм.

Хэлэлцүүлэг

Нүүдэлчдийн үйлдвэрлэл нь байгаль цаг уур, эрхлэх аж ахуйтайгаа нягт холбоотой хөгжиж ирсэн. Тэд ахуй амьдрал, өдөр тутмын хэрэгцээгээ хангахаас гадна нийгмийн нийтлэг үнэт зүйлийг бүтээхэд зориулан төмөр, төмөрлөг эдлэл (хүдэр хайлуулахаас дархлах), чулуу, бөс даавуу, арьс шир, мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байсан юм. Эдгээрээс төмөр, чулуу зэрэг материал бүхий эд зүйлс булш оршуулга, бууц суурины малтлагаас харьцангуй тогтвортой гарч байдаг. Харин даавуу, арьс шир, мод үйс зэрэг материалаар хийсэн эд зүйлс нь тухайн газар нутгийн байгаль орчин, хөрсний бүтэц зэргээс шалтгаалан алдаг оног гарах бөгөөд мөн тэдгээрийн зориулалт нь тэр бүр тодорхой байдаггүй.

Бидний тусгайлан авч үзэж буй үйс, үйсэн эдлэл төмрийн түрүү, хүннүгийн үеэс оршуулгын эд өлгийн чуулбар дотор нэлээд элбэг тохиолдож эхэлдэг. Энэ нь мэдээж тухайн үеэс үйсийг хэрэглэж эхэлсэн гэсэн үг биш бөгөөд харин оршуулгын бүтэц, зохион байгуулалт, зан үйл өөрчлөгдөн үхэгсдэд дагалдуулах эд зүйлийн төрөл, тоо нэмэгдсэнтэй холбоотой юм. Үйс нь байгаль дээр харьцангуй элбэг, гарын дор, хэлбэр хийц оруулж, зүйж оёход хялбар, чийг татахгүй, агаар нэвтрүүлж, гадагшлуулдаг гээд олон давуу талтай учир өнөөдрийг хүртэл өргөн хэрэглэсээр иржээ.


Хүний өдөр тутам хэрэглэж байдаг эд юмсын хүрээний нэн чухал хэсгийг бүрдүүлэгч чимэглэх урлагийн уран сайхны бүтээл өөрийн гоо сайхны эрхэмлээгээ, уран бүтэц, шинж чанараараа хүний оюун санаа, уран таалалд байнга нөлөөлж, түүний хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцаанд

нөлөөлдөг сэтгэл хөдлөлийн чухал эх булаг болдог байна. Мөн чимэглэх урлагт эд юмсын гоо сайхан, уялдаа зохилдлогооны харьцаа, хэм хэмжээний бүтэц бүхэн нь сэтгэл хөдөлгөсөн уран агуулгатай эдлэлийн нэгдмэл хэрэгсэл ажээ (Цэвээндорж 1999: 95).

Тиймээс ч бид үйсэн сав гэхээсээ илүүтэй түүнийг чимэглэсэн зураасан зурагт анхаарал хандуулж, хэд хэдэн асуултын хариултыг олохыг хичээсэн билээ.

Бидний эхний асуулт бол энэхүү үйсэн сав талийгаачид зориулан шинээр хийж тавьсан зүйл үү эсвэл өмнө хэрэглэж байсан зүйлийг дагалдуулсан зүйл үү гэдэг асуулт юм. Үйсэн савны дотор хүрэл толины хагархай (Зураг 2.) байсан нь тухайн толины үүрэг зориулалт, мөн түүнийг бүтэн хэмээн төсөөлсөн ч хэмжээ нь хамаагүй том байна. Тэгэхээр өмнө хэрэглэгдэж байсан эсвэл оршуулгад зориулан шинээр хийсэн саванд хүрэл толины хагархайг оршуулгын зан үйлийн утга агуулгын дагуу тавьсан бололтой. Өөр бусад хүннү булшинд хүрэл толь дагалдуулах нь түгээмэл байдаг хэдий ч үргэлж сав суулга дотор хийсэн зүйлгүй. Гэхдээ сонирхолтой нь Буриадын Царамын 7-р булшны хүрэл толины хагархай гэр, тэрэг дүрсэлсэн эвдэрсэн үйсэн савны дээрээс олдсон байдаг (Minyaev 2009: 55).

Харин дундад эртний Монголчуудын оршуулгад хүрэл толийг бөс даавуунд ороох, хавтага саванд хийх тохиолдлууд байдаг билээ (Эрдэнэбат 2020: 214). Мөн үйсэн савны дотор тослог эд зүйл болон ургамлын зүйл агуулж байсныг илтгэх баримт нүдэнд ил харагдаагүй юм. Оршуулгад зориулан шинээр хийсэн бол үйсэн савын урлаачид талийгаачийн туулж өнгөрүүлсэн амьдрал, оршуулгын үйл явц эсвэл нөгөө ертөнцийн талаарх утга агуулга бүхий зургаар чимэглэсэн байх боломжтой. Энэ саналыг дэмжих нэг баримт энэ оршуулгын 150-160 см гүнд 59×33,5 см хэмжээтэй модон жааз бүхий савхан модон бүтэц юм (Зураг 6). Бид энэхүү сараалж бүхий дөрвөлжин жааз



Зураг 5. Хятадын Гуанжоу хотын ойролцоох Зүүн Хан улсын үед холбогдох булинаас гарсан завины шавар баримал (Nanny Kim 2016:4. Figure 1)

болон хөндлөн банзнуудыг тэрэгний хэсэг хэмээн таамаглаж байгаа бөгөөд үүнтэй ижил дүрслэл үйсэн савны дүрслэлд бий (Зураг 3).

Хүннүгийн жирийн булшинд авсыг тэрэгний гуя, арал зэрэг модоор даруулж, таглаж тавих цөөнгүй байдаг. Жишээлбэл, Өвөрхангай аймгийн Тэвш ууланд 1972 онд малтсан 7, 8, 16, 20, 1977 онд малтсан 1-р булшинд нэвт нүхэлсэн, углуурга, ховилтой, зарим нь улаан будагтай өргөн, нарийн шургааг 4-30 ширхгийг хөл болон цээжин хэсэгт тавьсан байжээ. Түүнийг тухайн үед судлаачид тэрэгний арал данз, өжингийн хайсаар авсыг хамгаалан тавьсан нь хожмын монгол угсаатнуудын оршуулгын зан үйлтэй холбон тайлбарласан байдаг (Цэвээндорж 1987: 60-62, 73, 75).

Мөн Ховд аймгийн Шомбуузын бэлчрийн хүннү булшны 7, 12, 13, 15, 16, 20-р булшинд авсыг тэгш өнцөгт хэлбэрийн олон эм углуургатай тэрэгний гуя, данз, арал зэрэг модоор даруулж, таглаж тавьсан байжээ. Судлаачид чухам ямар хэлбэрийн тэрэг болохыг эдгээр хугархай зүйлсээс мэдэх боломжгүй хэмээгээд тэрэгний дугуй, тэнхлэг буюу голын мод гэх зүйл илрээгүй гэдгийг цохон тэмдэглэсэн байдаг. Мөн


тэд оршуулгад тэрэг дагалдуулах зан үйл Хүннүгээс гаралтай байж болно хэмээсэн байдаг (Баярсайхан нар 2011: 143, 145-148, 150, 152).

Мөн дундад зууны монголчууд тэмээ, сарлагийн нуруу ачихад хэрэглэдэг модон шатыг эвдэж хийсэн бололтой дамнуурга буюу шат, чарга мэт хэлбэртэй зүйл дээр шарилыг “орон” дээр тавьсан байдаг. “Үхдэлийн ор”-ыг оршуулгын газар шарилыг тээж авчирсан ямар нэгэн тээврийн хэрэгсэл буюу тэрэгний арал, шат, нуруу ачааг эвдэж, янгиа модыг янзлалгүйгээр угсарч хийх нь олонтоо байдаг. Зарим тохиолдолд шарил дээр тэрэгний арал, янгиа модыг хэмхчин хөмөрч орхих бай эсвэл шарилын баруун, зүүн хоёр талд модыг углуургаар нь салгаж, зэрэгцүүлэн тавина (Эрдэнэбат нар 2009: 13-14, 32).

Ийм зан үйл бүхий булш ихэвчлэн хадны оршуулгад тохиолддог бөгөөд үүнд Баянхонгор аймгийн Дугуй цахир, Цагаан хад (Ahres et al. 2015), Арцат дэл (Erdenebat et al. 2005) зэрэг дурсгалуудыг нэрлэж болно.

Бидний хоёр дахь асуулт бол эртний нүүдэлчдийн дүрслэх урлагийн чуулбарт болон археологийн эх хэрэглэгдэхүүнд дотор тэрэг харьцангуй олон

Хүснэгт 3: Бурхан толгой, Царам, Зүүн хотгор дэрсний хүннү булшны он цагийн харьцуулсан хүснэгт



Хүснэгт 4: Зураасан зурагт үйсэн сав бүхий хүннү булшны C14 он цагийн мэдээлэл

Булшны нэр, дугаар	Лабораторийн дугаар	BP	
Бурхан толгойн 79-р булш	UGAMS-76168	1930±20	95.4% 25 (91.9%) 168calAD 186 (3.5%) 203calAD
Царамын 7-р булш (Нийт 8 он цагийн үр дүн нийтлүүлснээс нэгийг сонгов (Miniaev S., Sakharovskaia L 2007:55))	Le-7680	1925±40	95.4% 8 (95.4%) 217calAD
Зүүн хотгор дэрсний 6-р булш (Ex.21.10)	UGAMS-64349	2080±20	95.4% 165 (94.0%) 42calBC 8 (1.4%) 2calBC



Зураг 6. Оршуулгын нүхнээс илэрсэн модон жааз бүхий сараалж

тохиолдож байгаагийн учир шалтгааныг тайлбарлах явдал юм. Мэдээж нүүдэлчдийн хувьд хөдлөх хүч, хөдөлгөөнт чанар хамгийн чухал бөгөөд түүнийг дэмжих гол хөшүүргийн нэг болох тэрэг чухал байр суурийг эзэлж ирсэн нь тодорхой. Тэрэг эхэн үедээ шинэ содон зүйл гэдэг утгаараа хадны зураг, буган хөшөө зэрэгт тусгалаа олж байсан бол түүнээс хожмын үест зарим талаараа эрх мэдэл, хүч чадлын бэлэг тэмдэг болж нийгмээс ялгарах өнцөг болж байжээ. Энэ нь хүннүгийн язгууртны болон том хэмжээтэй булшинд дагалдуулах гоёмсог сүйх тэрэгнүүд (Ерөөл-Эрдэнэ 2015: 74-80) болон түүний эд ангийг дагалдуулсан жижиг булшнуудаас харж болно (Амартүвшин нар 2023: 46).

Хожмын монголчуудын дунд ч гэсэн нүүдлийн хөсөг, тэрэгний тоо нь тухайн айлын хөрөнгө чинээг харуулахаас гадна зарим нутагт баян чинээлэг айлын хүүхэд, настныг нүүдэл болон аянд явахдаа сууж хэвтээд явдаг үүд гэгээвчтэй эсгий бүрээстэй мухлаг тэрэгтэй байсан тухай мэдээ бий (Жамсран 2012: 143).

Сүүлийн асуулт бол Хүннүгийн зураасан зургаар чимэглэсэн үйсэн сав олдсон Бурхан толгой, Царам, Зүүн хотгор дэрс хэмээх гурван газрын булшны оршуулгын зан үйл болон он цагт ижил зүйлс бий эсэхийг тодруулах явдал байв.

Эгийн голын Бурхан толгой, Ширийн чулууны Зүүн хотгор дэрсний хоёр булш нь хүннүгийн жирийн булшны төрөлд хамаарагдана. Бурхан толгойн 79-р булш нь 7 м голчтой чулуун дараастай, 280 гаруй см гүнд хүнээ хойш хандуулан чулуун болон модон

хашлаганд хийж тавьжээ. Оршуулга тоногдож, бог малын шаант бугалга, хавирга, нуруу, дал, бодын шагай зэрэг хойлгын малын яснууд, үйсний жижиг хэсэг, ясан савх, үйсэн таг зэрэг зүйлс үлдэж хоцорсон байжээ. Зүүн хотгор дэрсний 6-р булш 6,8 м голчтой чулуун дараастай, 2 м гаруй гүнд чанх хойш хандуулан хүнээ чулуун болон модон хашлаганд хийж тавьсан байна. Тоногдож сүйтгэгдсэн хэдий ч төмөр хадаас, хутга, хавтгай эдлэл зэрэг олон тоотой элдэв төмөр эдлэл, шилэн зүүлт, чулуун эдлэл, үйсэн сав, хүрэл толь, ясан савхны хугархай, ясан эдлэлийн хэсэг зэрэг цөөнгүй олдвор гаргасан юм.

Энэ хоёр булшны гадаад зохион байгуулалт нь ижил, дараас чулууны хэмжээ нь хүннүгийн дундаж булшинд тооцогдоно. Мөн талийгаачийг хойд зүг хандуулан 2 м гаруй гүнд чулуун хашлаганы дотуур модон хашлага хийн тавьсан болон ясан савх дагалдуулсан байдлаараа төстэй байх ажээ.

Царамын 7-р булш нь хүннүгийн язгууртны булшны төрөлд хамаарагдана. Үүдэвч бүхий дөрвөлжин хэлбэрийн бүтэцтэй. Дараас чулууны хэмжээ нь 32×32 м, хүнээ давхар бунханд хойд зүгт хандуулан оршуулсан бөгөөд тоногдож сүйтгэгдсэн. Гэхдээ оршуулгын түвшнээс мөнгө, хүрлээр хийсэн чимэглэл, алтаар шарсан хүний дүрст чимэглэл, чулуун эдлэл, хүрэл толь, төмөр эдлэл, үйсэн эдлэл, сүйх тэрэг болон түүнд холбогдох эд зүйл зэрэг ховор чамин олон олдвор гарсан байна (Миняев, Сахаровская 2007: 194-201).

Энэхүү булш нь Бурхан толгой, Зүүн хотгор дэрсний

булшнаас гадаад, дотоод зохион байгуулалтаараа эрс ялгаатай хэдий ч Зүүн хотгор дэрсний үйсэн сав болон хагархай хүрэл толь хамтдаа олдож байгаараа адил байгааг дээр дурдсан билээ.

Мөн бидэнд энэ гурван булшны радиокарбонь C14 лабораторийн үр дүн байгаа нь тэдний он цагийг харьцуулан авч үзэх таатай боломжийг олгосон юм (Хүснэгт 4). Гурван булшны он цаг нь хүннүгийн түүхэн он цагийн хүрээнд хамаарагдаж байгаа бөгөөд Бурхан толгой, Царамын булш нь НТ I зуунд бол харин Зүүн хотгор дэрсний булш харьцангуй эрт НТӨ I зуунд хамаарагдаж байна (Хүснэгт 3). Энэхүү он цагийн хүрээ нь ямартай ч хүннү нар бүс нутгийн болон нийгмийн бүлгийн ялгамжгүйгээр үйсэн савыг хэрэглэж улмаар оршуулгын зан үйлд ашигладаг байсныг гэрчилж байна. Мөн хүннү нар энэ хугацаанд хоёр болон дөрвөн дугуйтай тэрэг болон чарга (завь)-нд суурилуулсан зөөврийн сууц, бөмбөгөрдүү оройтой бүхээгийг түлхүү хэрэглэж байсныг тодруулах нэгэн баримт болох юм.

Дүгнэлт

Хүрэл зэвсгийн сүүл, төмрийн эхэн үеэс эхлэн эртний нүүдэлчид эрхлэх аж ахуйтай холбоотойгоор тэнгэр, газар, өвөг дээдсийнхээ сүнсийг тайж тахиш шүтлэгийн хэлбэрт аажмаар шилжихийн зэрэгцээ бичиг үсэг хэрэглэх болсон нь хад чулуунд зураг зурж, тахилга үйлддэг зан үйл аажмаар багасжээ (Батболд 2014: 125). Харин тэр үеэс тэд шавар, мод, үйс, ясан эдлэл дээрээ аж байдлын сэдэвтэй зураасан зураг зурахын зэрэгцээ тамга, үсэг сийлж эхэлсэн байдаг.

Энэ үеийн зарим сийлбэр нь хүний нүдэнд тэр бүр харагдаад байхааргүй шавар савны ёроол, нумын наалтын гадаргуу, дээврийн ваарын дээр байгаа нь тухайн урлаачийн өөрийн бүтээлийг тодотгох, мөнхжүүлэх нэг төрлийн “барааны тэмдэг” болж байжээ. Тэгвэл бидний тойрон хэлэлцэж буй үйсэн савны дээрх зураасан зургийн чимэглэл нь тухайн бүтээгдэхүүний үнэ цэн, утга агуулгыг нэмэгдүүлэхээс гадна үзэгчдийн анхаарлыг татах гоо үзэмжийг бий болгожээ.

Үйсэн савны дээр зураг зурж сийлсэн тохиолдол тийм олонгүй бөгөөд тэдгээрээс гурав дээр нь угсарч тавьсан тэрэг зурсан нь магадгүй баян чинээлэг, хүч чадал төгөлдөр байхыг бэлгэдэхийн зэрэгцээ нөгөө ертөнцөд хүргэх хөсгийг ч дүрсэлсэн (Төрбат 2004: 85) байх боломжтой юм.

Мөн бидний таамаглаж байгаагаар энэ булшны оршуулгын бүтцэд савхан модон сараалж бүхий жааз тавьсан нь тэрэгний эд анги мөн бол үйсэн саванд дүрсэлсэн сараалж цонхтой бүхээгт тэрэгтэй ямар нэгэн сэмжээр холбогдож байгаа нь лавтай. Өөрөөр хэлбэл, тэрэгний эд анги болон тэрэгний дүрслэл хоёр

нэгэн булшинд хамтдаа байж таарсан нь тухайн үеийн нэгэн төрлийн тэргийг нөхөн сэргээх таатай боломж юм.

Ингээд эцэст нь дүгнэхэд, Монголын зүүн өмнөд говийн бүсийн НТӨ I зууны үест хамаарагдах энгийн нэгэн тоногдож сүйтгэгдсэн хүннү булшнаас золоор харьцангуй сайн хадгалагдсан нэгэн үйсэн савны дээр уран нарийн биш ч гэлээ тухайн үеийн хөсөг тэрэгний олон хэлбэрийг тод томруун харуулсан үнэ цэнтэй зураасан зураг олдов. Энэхүү зураг нь цаашид хүннүгийн зураасан зургийн цуглуулгад томоохон байр суурь эзлэхийн зэрэгцээ нүүдэлчдийн гэр сууц, хөсөг тэрэгний үүсэл хөгжил, тэдний ертөнцийг үзэх үзэл, урлаг, гоозүйн мэдрэмж, үйлдвэрлэхүйн онцлогийг харуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн найдаж байна.

Талархал

Энэхүү өгүүллийг бичихэд гүн туслалцаа үзүүлж, хамтран ажилласан МУБИС-ийн багш, доктор Д.Одсүрэн, МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Б.Батдалай, АНУ-ын Ийелийн Их сургуулийн профессор Уильям Ханичёрч, доктор Д.Бөхчулуун, доктор Эйса Камерон (Asa Cameron), Канад улсын МакМастер Их сургуулийн докторант М.Адьяасүрэн, Чингис хааны өв соёлын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан И.Алтансүх, судлаач Ж.Тэнгис, О.Тэмүүлэн, жолооч Т.Болдбаатар нартаа баярласнаа илэрхийлье.

Abstract

A Birch bark vessel decorated with drawings

Chunag Amartuvshin and Bayanbileg Dashzeveg

This article is about a birch bark vessel with drawings found in the Xiongnu burial of the Zuun khotgor ders of Shiriin Chuluu, Altanshiree soum, Dornogovi aimag. In discussing this, we will consider the original materials we have collected on the use and traditions of birch bark by peoples and nomads of the world, as well as our opinions on the narrative and meaning of the drawings on the birch bark vessel. We will also briefly touch on the specific features of the burial rituals of the burial where the find was found and the chronological issues.

Keywords: Xiongnu, birch bark vessel, drawings

Ном зүй

Амартүвшин, Ч., Одсүрэн, Д., Батдалай, Б., Бөхчулуун, Д., Эйса Камерон, Адьяасүрэн, М., Дашзэвэг, Б. (2022). Монгол-Америкийн хамтарсан “Товийн бүс нутгийн археологийн судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2021 оны тайлан. ШУА-ийн АХГБСХ. УБ.

Амартүвшин, Ч., Хатанбаатар, П. (2010). Хүннү булшны судалгаа. Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу. УБ.

Амартүвшин, Ч., Шелах, Г., Ханичёрч, У., Даниела, В., Роговски, Т., Ангарагдөлгөөн, Г., Дашзэвэг, Б., Үүрийнтуяа, Б., Мөнх-Учрал, М. (2023). Монгол-Израилийн хамтарсан “Дорнод Монголын хэрэмт хотын судалгаа” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2023 оны тайлан. МУИС-ийн НАХ-ийн сан хөмрөг. УБ.

Арциховский, А.В., Янин, В.Л. (1978). Новгородские грамоты на Бресте (Из раскопок 1962-1976 гг.) М.

Баатархүү, Б., Одсүрэн, Д. (2015). Монгол гэр. Тайлбар толь. УБ.

Бадамхатан, С. (1962). Хөвсгөлийн цаатан ардын аж байдлын тойм. УБ.

Бадамхатан, С. (2012). Тува цаатан. Монгол Улсын угсаатны зүй. Монгол түрэг, хамниган овогтны угсаатны зүй. III боть. УБ.

Бадарч, Н., Жамбалжамц, Б. (1969). Уур амьсгал. Монгол орны физик газар зүй. Редактор академич Ш.Цэгмид. УБ.

Батболд, Н. (2014). Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ.

Батнасан, Г. (2012). Гэр зуурын үйлдвэр. Аж ахуй. Буриад. Монгол, түрэг, хамниган овогтны угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе. III боть. Монгол Улсын угсаатны зүй. Нэмэн засварласан хоёрдахь хэвлэл. УБ.

Батнасан, Г. (2012). Оюуны соёл. Буриад. Монгол улсын угсаатны зүй (Монгол, түрэг, хамниган овогтны угсаатны зүй) III боть. Нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ.

Баттуяа, О. (2006). Монгол хамниганы гэр ахуйн модон эдлэл. *Studia Ethnologica*. Tom. XVII, fasc. 5. УБ.

Баярсайхан, Ж., Эгиймаа, Ц., Браян Миллер, Коновалов, П.Б., Жохенсон Эрик, Мишел Махичек, Жүди Логан, Клейр Нейли. (2011). Шомбуузын бэлчир дэх хүннүгийн дурсгал. Нүүдэлчдийн өв судлал. Tom. XI, Fasc. 12. УБ.

Гантогтох, Г. (2012). Буриадын бөө мөргөл. - Монгол Улсын угсаатны зүй. Монгол түрэг, хамниган овогтны угсаатны зүй. III боть. УБ.

Диосеги, В. (1950). Берестовая посуда у манджуротунгусов и методы ее изготовления. Будапешт.

Дисан, Т. (2012) Уламжлалт шүтлэг. Үзэмчин. Монгол Улсын угсаатны зүй (монгол, түрэг, хамниган

овогтны угсаатны зүй). Боть III. УБ.

Дисан, Т. (2012). Гар үйлдвэрлэл. Монголын угсаатан зүй. Халхын угсаатны зүй. I боть. УБ.

Ерөөл-Эрдэнэ, Ч. (2015). Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа. Монголын археологийн шинэ судалгаа. Цуврал-1. УБ.

Ерөөл-Эрдэнэ, Ч., Гантулга, Ж. (2017). Хүннүгийн үеийн сүйх тэрэг. *Studia Archaeologica*. Tom. XXII, Fasc. 18. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Амгаланбат, Б., Даваахүү, Э. (2017). Хавцгайтын амны хадны зураг дахь Монгол гүрний үеийн өвөрмөц дүрслэлийн тухайд. *Studia Archaeologica*. Tom. XXXVI, Fasc. 23. УБ.

Миняев, С.С., Сахаровская, Л.М. (2007). Элитный комплекс захоронений сюнну в пади Царам. Российская археология. 2007, №1, М.

Монгол гэр. (2015). Эмхэтгэсэн Х.Батсайхан, Р.Ундрахбаяр. УБ.

Нандинцэцэг, Н. (2023). Үйсэн эдлэлийн хадгалалт хамгаалалт, туршлага /Хүннүгийн булшнаас илэрсэн үйсэн савны жишээгээр/. *Studia Archaeologica*. Tom. XLIII, Fasc. 10. УБ.

Окладников, А.П. (1959). Шишкинские писаницы: Памятник древней культуры Прибайкалья. Иркутск.

Тангад, Д. (2012). Торгууд. Монгол Улсын угсаатны зүй. Ойрадын угсаатны зүй. II боть. УБ.

Тангад, Д. (2012). Хамниган. Монгол Улсын угсаатны зүй. Монгол түрэг, хамниган овогтны угсаатны зүй. III боть. УБ.

Төрбат, Ц., Амартүвшин, Ч., Эрдэнэбат, У. (2003). Эгийн голын археологийн дурсгалууд. УБ.

Төрбат, Ц. (2015). Эгийн голын хүннү булшнаас гарсан үйсэн дээрх тэрэгний зураг. Монгол-Францын археологийн нээлтүүд. Хорин жилийн хамтын ажиллагаа. Үзэсгэлэнгийн каталоги. УБ.

Түвшинжаргал, Т., Тэйлор, В. (2019). Гэрийн эртний түүхэн хөгжлийг археологийн хэрэглэгдэхүүнээр тодруулах нь. Монгол гэрийн өв соёл. УБ.

Цолмон, С. (2002). Монголчууд хусны үйсийг бичгийн хэрэглэл болгон ашиглаж байсан уламжлалаас. *Studia Ethnologica*. Tom. XIV, Fasc.3. УБ.

Цэвээндорж, Д. (1987). Хүннүгийн археологи. – Монголын археологи. Редактор Н.Сэр-Оджав. II бүлэг, §1. *Studia Archaeologica*. Tom. XII, Fasc. 1. УБ.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн түүх. УБ.

Шренк, Л. (1883). Об инородцах Амурского края. Санкт-Петербург. Хавсралт XII, зур. 8.

Эгиймаа, Ц. (2003). Хүннүгийн зураасан зургийн дурсгал. *Studia Archaeologica*. Tom. I (XXI), Fasc.7. УБ.

Энх-Амгалан, Л., Мөнхгэрэл, Л., Баярмаа Б. (2020). Хусны үйснээс бетулин гарган авах технологийн судалгаа. Эрдэм шинжилгээний бүтээл. ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэн. No8. УБ.

Эрдэнэбат, У. (2020). Монгол булш, түүний хэв шинж, онцлог. Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил. УБ.

Эрдэнэбат, У., Амартүвшин, Ч. (2009). Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун). УБ.

Эрэгзэн, Г. (2024). Хүннүгийн язгууртны булшны холбогдох он цаг ба хувьсал хөгжлийн асуудал. *Studia Archaeologica*. Tom. XLIV, Fasc.9. УБ. DOI: <https://doi.org/10.5564/sa.v44i1.3522>

Beck, P., Caudullo, G., de Rigo, D., Tinner, W. (2016). *Betula pendula*, *Betula pubescens* and other birches in Europe: distribution, habitat, usage and threats. In: San-Miguel-Ayanz, J., de Rigo, D., Caudullo, G., Houston Durrant, T., Mauri, A. (Eds.), *European Atlas of Forest Tree Species*. Publ. Off. EU, Luxembourg.

Birte Ahrens, Gončigsüren Nomguunsüren, Henny Piezonka, Holger Becker, Regina Klee, Michelle Machicek, Bruno Frohlich und Tsend Amgalantugs. (2015). Das mittelalterliche Höhlengrab von Cagaan Chad, Mongolei Eine Kriegerbestattung am nördlichen Rand der Wüste Gobi. *ZAM Zeitschrift für Archäologie des Mittelalters*, Jahrgang 43, 2015, Seiten 59–126. Verlag Dr. Rudolf Habelt GmbH, Bonn

Christina Carolus, Asa Cameron, Bukhchuluun Dashzeveg, Chunag Amartuvshin, Byambatseren Batdalai, Gabat Dashzeveg, Davaakhuu Odsuren, Molor Adiyasuren. (2024). Ritual birch bark traditions in prehistoric Eurasia: A Case study from the Mongolia Gobi. *Arctic Studies Center. Newsletter. Smithsonian Institution. National Museum of Natural History*. May 2024. Number 31.

Derek Hayes. *Historical Atlas of Canada. Canada's History Illustrated with Original Maps*. Library and Archives Canada Cataloguing in Publication. 2015. Pp. 152

Jeremiah P. Losty. (1982). *The Art of the Book in India*. The British Library. London.

Joost H. Crouwel, Gail Brownrigg and Kathryn Linduff. (2024). *From Chariot Carriage: Wheeled Vehicles and Developments in Draft and Harnessing in Ancient China*. – *Sino-Platonic Papers*. Number 344. University of Pennsylvania. USA.

Koropachinskii, I.Y. (2013) Natural hybridization and taxonomy of birches in North Asia. *Contemp. Probl. Ecol.* 6, 350–369 (2013). <https://doi.org/10.1134/S1995425513040045>

Mao Qiaozhi, Watanabe Makoto, Koike Takayoshi. (2010). Growth Characteristics of Two Promising Tree Species for Afforestation, Birch and Larch in the Northeastern Part of Asia. *Eurasian J. For. Res.* 13-2: 69–76, 2010. Hokkaido University Forests. EFRC.

Minyaev, S. (2009). Tsaram: A Burial ground of the Hsiung-Nu elite in Transbaikalia. *Archaeology Ethnology & Anthropology of Eurasia* 37/2 (2009) 49–58. DOI:10.1016/j.aear.2009.08.011

Patrick Schmidt, Matthias Blessing, Maxime Rageot, Radu Lovita, Johannes Pfleging, Klaus G. Nickel, Ludovic Righetti, Claudio Tennie. (2019). Birch tar production does not prove Neanderthal behavioral complexity. *Proc Natl Acad Sci USA*. 2019 Sep 3; 116 (36): 17707–17711. doi: 10.1073/pnas.1911137116

Sergei S. Miniaev, Lidiia M. Sakharovskaia. (2007). Investigation of a Xiongnu Royal Complex in the Tsaraam Valley. Part 2: The Inventory of Barrow No. 7. The Silk Road. Vol. 5. Number 1. The Silkroad Foundation. Saratoga, CA. USA


Shannon Croft and Rolf W. Mathewes. (2013). *Barking Up the Right Tree: Understanding Birch Bark Artifacts from the Canadian Plateau*, British Columbia. *BC Studies*. No180, Winter 2013/14. Pp. 83–122.

Ulambayar Erdenebat, Ernst Pohl. (2005). *Felsspalten- und Höhlenbestattungen in der Mongolei*. In: *Dschingis Khan und seine Erben. Das Weltreich der Mongolen*. Bonn / Muenchen.

Received: Nov. 14, 2025; Revised: Dec. 1, 2025; Accepted: Dec. 10, 2025









Хавсралт 1: Монгол болон хөрш зэргэлдээ улсад тэмдэглэгдсэн зарим гэрийн дүрслэлийн товч мэдээлэл

Дүрслэл	Дурсгалт газрын нэр	Улс, аймаг, сум	Дурсгал болон он цаг	Ном зүй
	Арвайхээр	Өвөрхангай, Арвайхээр	Хадны зураг / Хүрэл зэвсгийн үе	(Окладников 1981:154. Табл. 70)
	Бичигтийн ам	Баянхонгор, Баянлиг	Хадны зураг / Хүрэл зэвсгийн үе	(Цэвээндорж 2003:54. 7-р зураг)
	Бичигтийн ам	Баянхонгор, Баянлиг	Хадны зураг / Хүрэл зэвсгийн үе	(Цэвээндорж 2003:54. 4, 5-р зураг)
 	Бояр	ОХУ, Хакасын БНУ	Хадны зураг / НТӨ VII-III зуунд буюу Тагарын соёл болон НТӨ II-I зууны Таштык соёлд зарим нь хамаарна.	(Дэвлет 1976: 8. Таб. 5)
	Дэл уул	Дундговь, Өлзийт	Хадны зураг / Дундад зууны үе	(Түвшинжаргал, Тэйлор 2019: 8. Зураг 8) (Сүхбаатар нар.,2017:124, 131)
	Дэл уул	Дундговь, Өлзийт	Хадны зураг / XI-XIV зуун	(Баатархүү, Жигмэддорж 2004: 64-72. Зураг 1)
	Зүүн Хотгор дэрсний 6-р булш (Ех.10.21)	Дорноговь, Алтанширээ	Үйсэн эдлэл / Хүннү	Christina Carolus et al., 2024:50-53. Амартүвшин нар.,2022: 47-52. Зураг 60, 66, 67, 68, 69.

	Монь уул	БНХАУ, ӨМӨЗО	Хадны зураг /	(中国岩画发现史 1991:316) (盖山林, 1995: 109. Зураг 107).
	Олон овоо	БНХАУ, ӨМӨЗО	Хадны зураг / 3500-2000 BP	(Terguunbayar 2023:1- 47. Figure 16) (Тэргүүнбаяр 2022:149)
	Тээгийн өвөр	Говь-Алтай, Тайшир	Хадны зураг /	Төрбат нар 2023
	Хужирт	Өвөрхангай, Хужирт	Хадны зураг / хүрэл зэвсгийн үе	(Окладников 1981:147, Табл. 63)
	Цагаан туруут	Баянхонгор, Галуут, Өлзийтийн хошуу	Хадны зураг / Хүннү ба ойролцоо үе	(Түвшинжаргал, Тэйлор 2019: 10. Зураг 11)
	Юймэнь	БНХАУ, Ганьсу	Авсны мол / НТ IV-V зуун	(Andreeva, Atwood 2018:101-109. Fig 5)

Хавсралт 2: Монгол болон хөрш зэргэлдээ улсад тэмдэглэгдсэн зарим тэрэгний дүрслэлийн товч мэдээлэл

Дүрслэл	Дурсгалт газрын нэр	Улс, аймаг, сум	Дурсгал болон он цаг	Ном зүй
	Баянзүрх	Казахстан, Зүүнгар, Алатау, Семиречье	Хадны зураг / хүрэл зэвсгийн үе	(Самашев 2012:108. Рис.88)
	Баянзүрх	Казахстан, Зүүнгар, Алатау, Семиречье	Хадны зураг / хүрэл зэвсгийн үе	(Самашев 2012:102-105)
	Бичигтийн ам	Баянхонгор, Баянлиг	Хадны зураг / Хүрэл зэвсгийн үе	(Цэвээндорж 2003:54. 7-р зураг)
	Бурхан толгойн 79-р булш	Булган, Хутаг-Өндөр, Эгийн гол	Үйсэн эдлэл / НТӨ I – НТ I зуун	(Төрбат 2015:49-53) (Эгиймаа 2003:69-74)
	Дэл уул	Дундговь, Өлзийт	Хадны зураг / НТӨ I – НТ I зуун	(Баттулга 1998:109-113. Зураг 7)
	Зүүн Хотгор дэрсний 6-р булш (Ex.10.21)	Дорноговь, Алтанширээ	Үйсэн эдлэл / Хүннү	Christina Carolus et al., 2024:50-53. Амаргүвшин нар., 2022: 47-52. Зураг 60, 66, 67, 68, 69.

	Каратау	Казахстан, Сауыскандык	(Алтынбеков, Новоженов, 2014:341. Рис.11.7).	
	Сулук	Хакас	(Алтынбеков, Новоженов, 2014:341. Рис.11.2).	
	Табангут овоо	ОХУ, Байгал нуур	(Алтынбеков, Новоженов, 2014:341. Рис.11.4)	
	Тээгийн өвөр	Говь-Алтай, Тайшир	Хадны зураг /	(Дашзэвэг, Золжаргал 2024:155. Зураг 6)
	Хавцгайт	Өмнөговь, Булган	Хадны зураг / XIII-XIV зуун НТӨ IV-I зуун	(Идэрхангай нар 2017:317-330. Зураг 2) (Andreeva, Atwood 2018:101-109. Fig 5)
	Царамын 7-р булш	ОХУ, Буриадын БНУ	Үйсэн эдлэл / Хүннү 2120+30 192BCE- 52BCE	(Minyaev 2009:49–58. Fig. 10. Pp.55) (Миняев, Сахаровская 2007:194-201. Рис. 3: 2, 3) (Minyaev, Sakharovs- kaia 2007:55)

	Шишкино	ОХУ-ын Эрхүү муж	Хадны зураг / XIII-XIV зуун	Окладников 1959:171; Рис.102
	Шишкино	ОХУ-ын Эрхүү муж	Хадны зураг / XIII-XIV зуун	Окладников 1959:171; Рис.103
	Юймэнь	БНХАУ, Ганьсу	Авсны мол / НТ IV-V зуун	(Andreeva, Atwood 2018:101-109. Fig 5)
	Ямаан ус	Ховд, Эрдэнэбүрэн	Хүннү	(Дорж, Новгородова 1975:75-76. Рис.6,7).